



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны G-9218MON тоот буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн дагуу “Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хөрөнгөд бүртгэлтэй, 10 нэрийн, нийт 29,900,000.00 (хорин есөн сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 22,209,722.22 (хорин хоёр сая хоёр зуун есөн мянга долоон зуун хорин хоёр төгрөг хорин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, “Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн зохицуулагч Н.Хүрэлбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгө хүлээн авсны дараа үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналаа ирүүлж шийдвэрлүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132080817
10-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 04 дугаар сарын 01-ны нийгдрийн
0282 дугаар тогтоолын хавсралт

"ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ШУУРХАЙ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦООНЫ
ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ"-ИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМАНД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Балансын нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Оффис ширээ түмбүктэй	2022.08.26	4	850,000.00	3,400,000.00	878,333.33	2,521,666.67
2	Мэргэжилтнүүдийн сандал	2022.08.26	4	275,000.00	1,100,000.00	284,166.67	815,833.33
3	Оффис ширээ түмбүктэй	2022.08.26	1	1,100,000.00	1,100,000.00	284,166.67	815,833.33
4	Менежерийн сандал	2022.08.26	1	420,000.00	420,000.00	108,500.00	311,500.00
5	Шкаф	2022.08.26	2	990,000.00	1,980,000.00	511,500.00	1,468,500.00
6	Зөөврийн компьютер-/vostro/	2022.08.26	2	2,622,000.00	5,244,000.00	4,515,666.67	728,333.33
7	Зөөврийн компьютер- /inspiron 3511/	2022.08.26	2	2,932,500.00	5,865,000.00	5,050,416.67	814,583.33
8	Принтер- Принтер /laser jet MfP 179 /	2022.08.26	1	1,466,000.00	1,466,000.00	1,262,388.89	203,611.11
9	Рүүтер -/TP link c24 wifi/	2022.08.26	1	75,000.00	75,000.00	64,583.33	10,416.67
10	Санхүүгийн программ-/Инфосистем/	2022.08.26	1	9,250,000.00	9,250,000.00	9,250,000.00	-
				19	29,900,000.00	22,209,722.22	7,690,277.78
НИЙТ ДҮН					(хорин есөн сая есөн зуун мянга)	(хорин хоёр сая хоёр зуун есөн мянга долоон зуун хорин хоёр төгрөг хорин хоёр мөнгө)	(долоон сая зургаан зуун ерэн мянга хоёр зуун далан долоон төгрөг далан найман мөнгө)